




САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/52/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Говь-Алтай аймаг Алтай хот 2021 он	Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас:70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 70484030 Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	11
4. Аудитын илрүүлэлт	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГА
Ш.МЭНДСАЙХАН ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 35
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

07020204

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	646,255,804.84	2,719,361,694.30
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0	10,039,058.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0	10,039,058.00
31210	Төгрөг	0	10,039,058.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0	10,039,058.00
33	АВЛАГА	4,283,855.00	1,597,376,021.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0	1,595,252,021.00
33500	Бусад авлага	4,283,855.00	2,124,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	4,283,855.00	2,124,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	641,971,949.84	1,111,946,615.30
35100	Түүхий эд материал	253,497,237.54	653,881,156.06
35110	Тусгай зориулалттай материал	38,844,542.00	173,153,095.00
35130	Эм боох материал	214,652,695.54	480,728,061.06
35400	Хангамжийн материал	388,474,712.30	458,065,459.24
35410	Бичиг хэргийн материал	8,084,925.00	9,771,500.00
35420	Аж ахуйн материал	18,395,505.00	27,639,900.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5,641,175.00	3,280,656.00
35440	Түлш, шатах тослох материал	6,581,277.00	2,320,418.00
35450	Барилгын засварын материал	19,568,890.00	5,894,000.00
35460	Хүнсний материал	35,224,194.00	87,742,724.00
35470	Бусад хангамжийн материал	294,978,746.30	321,416,261.24
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,769,294,185.01	18,191,109,988.83
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,769,294,185.01	18,191,109,988.83
39200	Биет хөрөнгө	15,391,802,834.96	17,782,664,516.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	11,390,608,967.14	12,454,143,437.14
39202	Хуримтлагдсан элэгдэл	-615,415,087.92	-926,936,906.88
39203	Авто-тээврийн хэрэгсэл	328,337,090.00	339,837,090.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-198,349,397.58	-239,894,572.02
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	5,280,162,869.59	8,670,616,436.59
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,011,371,228.58	-2,710,661,433.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	289,661,898.20	300,272,313.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	-71,832,275.89	-104,711,847.71
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,158,500.00	6,158,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,158,500.00	-6,158,500.00
39300	Биет бус хөрөнгө	377,491,350.05	408,445,472.13
39301	Програм хангамж	22,642,500.00	53,904,622.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-21,358,949.95	-21,666,949.87
39303	Бусад биет бус хөрөнгө	376,207,800.00	376,207,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	16,415,549,989.85	20,910,471,683.13
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	1,128,132,877.56
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	1,128,132,877.56
41300	Өглөг	0	1,128,132,877.56
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	1,049,746,746.56
41360	Бусад өглөг	0	78,386,131.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0	56,017,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0	22,369,131.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	16,415,549,989.85	19,782,338,805.57
51	Засгийн газрын хувь оролцоо	16,415,549,989.85	19,782,338,805.57
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	8,279,908,710.20	8,279,908,710.20
51200	Хуримтлагдсан үр дүн	4,014,122,623.27	7,381,438,132.24
51210	Өмнөх үеийн үр дүн	1,839,506,112.55	4,014,649,316.52
51220	Тайлант үеийн үр дүн	2,174,616,510.72	3,366,788,815.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,121,518,656.38	4,120,991,963.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	16,415,549,989.85	20,910,471,683.13

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,642,371,479.86	16,301,794,797.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,704,678,563.86	5,556,268,305.46
120	Нийтлэг татварын бус орлого	2,704,678,563.86	5,556,268,305.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	192,848,777.00	125,536,112.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	158,558,710.00	125,536,112.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,290,067.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	2,384,941,242.00	4,623,785,421.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	126,888,544.86	806,946,772.46
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,937,692,916.00	10,745,526,492.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,965,468,100.00	0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,965,468,100.00	0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	118,814,004.00	717,426,451.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0	15,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,728,040.00	516,090,856.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	34,085,964.00	172,730,595.00
131106	Хаагдсан данс	0	0
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0	13,605,000.00
1330	Төсвийн захирагчдаас	0	325,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	0	200,000,000.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	0	125,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,853,410,812.00	9,703,100,041.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,853,410,812.00	9,703,100,041.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,451,152,469.14	12,932,672,648.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,451,152,469.14	12,932,672,648.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,437,305,414.14	12,427,284,335.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,649,910,061.00	4,932,553,897.00
210101	Үндсэн цалин	2,710,046,903.00	2,901,041,106.00
210102	Нэмэгдэл	1,375,607,700.00	1,539,885,050.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	195,369,000.00	199,632,000.00
210104	Урамшуулал	368,886,458.00	291,995,741.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	586,623,243.00	645,460,665.00
210201	Тэтгэврийн даатгал	406,108,143.00	450,623,865.00
210202	Тэтгэмжийн даатгал	45,128,800.00	48,709,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	36,103,000.00	38,967,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	9,025,800.00	9,741,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	90,257,500.00	97,418,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	799,196,934.00	874,407,042.00
210301	Гэрэл, цахилгаан	61,554,624.00	79,317,328.00
210302	Түлш, халаалт	563,375,162.00	639,067,122.00
210303	Цэвэр, бохир ус	174,267,148.00	156,022,592.00
2104	Хангамж, бараа материалын зардал	181,648,067.37	271,755,931.06
210401	Бичиг хэрэг	17,608,550.00	26,127,400.00
210402	Тээвэр, шатахуун	43,746,269.00	72,733,179.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,659,180.00	14,970,987.00
210404	Ном, хэвлэл	160,000.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	54,543,169.00	101,337,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,683,700.00	26,966,305.00
210408	Бараа материал акталсны зардал	34,247,199.37	29,620,960.06
2105	Нормативт зардал	1,584,176,039.54	3,364,773,762.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,424,464,603.54	3,062,347,747.50
210502	Хоол, хүнс	146,836,036.00	295,292,065.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,875,400.00	7,133,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	190,590,206.00	87,574,079.00
210604	Урсгал засвар	190,590,206.00	87,574,079.00
2107	Томилолт, зочны зардал	12,765,900.00	8,368,000.00
210702	Дотоод албан томилолт	12,765,900.00	8,368,000.00

Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,137,010.00	12,387,575.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,845,250.00	1,918,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,812,000.00	456,850.00
210803	Даатгалын үйлчилгээ	950,050.00	669,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	365,200.00	231,650.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	286,000.00	308,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	120,000.00	0
210807	Газрын төлбөр	780,920.00	806,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	725,900.00	1,612,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	12,251,690.00	6,384,125.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	412,257,953.23	2,230,003,383.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,498,741.00	1,380,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,160,000.00	16,628,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	394,599,212.23	2,211,994,783.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,847,055.00	505,388,313.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,696,400.00	505,388,313.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,696,400.00	505,388,313.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	150,655.00	0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,655.00	0
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	144,000.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,191,219,010.72	3,369,122,149.08
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	16,602,500.00	2,333,333.36
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	16,602,500.00	2,333,333.36
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,174,616,510.72	3,366,788,815.72

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,279,908,710.20	4,122,695,414.72	1,838,329,354.21	14,240,933,479.13
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	1,176,758.34	1,176,758.34
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,279,908,710.20	4,122,695,414.72	1,839,506,112.55	14,242,110,237.47
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-1,176,758.34	0	-1,176,758.34
9	Тайлант үеийн үр дүн	0	0	2,174,616,510.72	2,174,616,510.72
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,279,908,710.20	4,121,518,656.38	4,014,122,623.27	16,415,549,989.85
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,279,908,710.20	4,121,518,656.38	4,014,122,623.27	16,415,549,989.85
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	526,693.25	526,693.25
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,279,908,710.20	4,121,518,656.38	4,014,649,316.52	16,416,076,683.10
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-526,693.25	0	-526,693.25
19	Тайлант үеийн үр дүн	0	0	3,366,788,815.72	3,366,788,815.72
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	8,279,908,710.20	4,120,991,963.13	7,381,438,132.24	19,782,338,805.57

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	8,097,008,706.00	9,280,187,763.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	158,558,710.00	125,536,112.00
120	Нийтлэг татварын бус орлого	158,558,710.00	125,536,112.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	158,558,710.00	125,536,112.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	158,558,710.00	125,536,112.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,938,449,996.00	9,154,651,651.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,965,468,100.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,965,468,100.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	119,571,084.00	721,803,631.00

Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0	15,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,728,040.00	516,090,856.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	34,843,044.00	177,107,775.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0	13,605,000.00
1330	Төсвийн захирагчдаас	0	325,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	0	200,000,000.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	0	125,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,853,410,812.00	8,107,848,020.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,853,410,812.00	8,107,848,020.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,014,296,306.00	9,257,790,205.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,014,296,306.00	9,257,790,205.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,000,449,251.00	8,752,401,892.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,647,198,916.00	4,930,417,618.00
210101	Үндсэн цалин	2,707,335,758.00	2,898,904,827.00
210102	Нэмэгдэл	1,375,607,700.00	1,539,885,050.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	195,369,000.00	199,632,000.00
210104	Урамшуулал	368,886,458.00	291,995,741.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	586,623,243.00	645,437,089.00
210201	Тэтгэврийн даатгал	406,108,143.00	450,600,289.00
210202	Тэтгэмжийн даатгал	45,128,800.00	48,709,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	36,103,000.00	38,967,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	9,025,800.00	9,741,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	90,257,500.00	97,418,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	799,196,934.00	610,824,926.00
210301	Гэрэл, цахилгаан	61,554,624.00	79,317,328.00
210302	Түлш, халаалт	563,375,162.00	375,485,006.00
210303	Цэвэр, бохир ус	174,267,148.00	156,022,592.00
2104	Хангамж, бараа материалын зардал	170,370,880.00	248,376,467.00
210401	Бичиг хэрэг	16,912,100.00	26,287,000.00
210402	Тээвэр, шатахуун	43,754,650.00	67,472,320.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,659,180.00	14,970,987.00
210404	Ном, хэвлэл	160,000.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	55,664,150.00	109,317,550.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	38,220,800.00	30,328,610.00
2105	Нормативт зардал	1,558,112,099.00	2,196,987,772.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,367,083,504.00	1,922,239,323.00
210502	Хоол, хүнс	137,083,640.00	265,869,499.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	53,944,955.00	8,878,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	188,132,303.00	80,702,870.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,684,500.00	0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,720,000.00	0
210604	Урсгал засвар	181,727,803.00	80,702,870.00
2107	Томилолт, зочны зардал	12,765,900.00	8,368,000.00
210701	Гадаад албан томилолт	0	0
210702	Дотоод албан томилолт	12,765,900.00	8,368,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,390,235.00	13,278,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,845,250.00	1,918,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,812,000.00	456,850.00
210803	Даатгалын үйлчилгээ	950,050.00	669,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	365,200.00	231,650.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	286,000.00	308,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	120,000.00	0
210807	Газрын төлбөр	780,920.00	806,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,630,900.00	1,612,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11,599,915.00	7,275,100.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,658,741.00	18,008,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,498,741.00	1,380,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,160,000.00	16,628,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,847,055.00	505,388,313.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,696,400.00	505,388,313.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,696,400.00	505,388,313.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	150,655.00	0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,655.00	0
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	144,000.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	82,712,400.00	22,397,558.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	82,712,400.00	12,358,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	82,712,400.00	12,358,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	82,712,400.00	12,358,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	82,712,400.00	12,358,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-82,712,400.00	-12,358,500.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	10,039,058.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	10,039,058.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Гүйцэтгэлээр санхүүжиж байгаа тул төсвийн гүйцэтгэлийн тайлан баталгаажуулаагүй.

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	711,764,573.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	711,764,573.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	215,105,560.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,848,810.00
210101	Үндсэн цалин	8,848,810.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,194,589.00
210201	Тэтгэврийн даатгал	1,194,589.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,232,600.00
210401	Бичиг хэрэг	1,575,800.00
210402	Тээвэр, шатахуун	1,637,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,659,000.00
2105	Нормативт зардал	127,718,991.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	125,968,991.00
210502	Хоол, хүнс	1,750,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,389,970.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,398,600.00
210604	Урсгал засвар	36,991,370.00
2107	Томилолт, зочны зардал	1,712,000.00
210702	Дотоод албан томилолт	1,712,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,008,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,380,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,628,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	496,659,013.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	496,659,013.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	496,659,013.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	721,803,631.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	721,803,631.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	516,090,856.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	177,107,775.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	13,605,000.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	10,039,058.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,039,058.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, татварын байгууллагатай тооцоо нийлж санхүүгийн тайланг бодитой үнэн зөв хөтлөхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ж.Бүжинханд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Нэгдсэн эмнэлэг нь аймгийн нийт хүн амд 2 дахь шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт өөрчлөлт орсон байна. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 03 дугаар тогтоол, Эмнэлгийн тусламжийн хуулийн дагуу тус байгууллагыг гүйцэтгэлээр санхүүжүүлж байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж байхгүй. Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 8,451.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 169.0 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 12,932.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 258.6 сая төгрөгөөр тооцсон. АДБОУС 2320-н 13-д зааснаар санхүүгийн тайланд анхлан тогтоосноос бага материаллаг байдал зохистой тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Нэгдсэн эмнэлэг нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 27.4 хувиар буюу 4,494.9 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 4.2 сая төгрөг нь ажиллагсадтай холбоотой авлага байсан. Тайлант оны эцэст 1,597.3 сая төгрөгийн авлага тайлагнасны 1,595.2 сая төгрөг нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах, 2.1 сая төгрөг нь хувь хүмүүсээс авах авлага байна. Хувь хүмүүсээс авах авлагыг хуулийн байгууллагад хандсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,111.9 сая төгрөг болж 469.9 сая төгрөгөөр өссөн нь эм боох, бичиг хэрэг, аж ахуйн, хүнс, бусад хангамжийн материалын үлдэгдэл өссөнтэй холбоотой. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 3,374.3 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 806.9 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үйл ажиллагаандаа 3,662.8 сая төгрөгийн материалыг зарцуулан, 4.4 сая төгрөгийн цус цусан бүтээгдэхүүн, эм эмнэлгийн бүтээгдэхүүнийг худалдаж, 14.4 сая төгрөгийн эмийг бэлтгэн нийлүүлэгчид буцаан, 29.7

сая төгрөгийн хөрөнгийг акталж оны эцэст 1,111.9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 22,201.1 сая төгрөг болж 4,507.4 сая төгрөгөөр өссөн. Төсвийн хөрөнгөөр 12.4 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэн, 4,623.0 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авчээ. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор 125.3 сая төгрөгийн хөрөнгийг акталж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор 3.5 сая төгрөгийн авто машиныг ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албанд шилжүүлэн тайлант оны эцэст 22,201.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 19,782.3 сая төгрөг болж 3,366.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 0.5 сая төгрөгийн бичилт хийгдсэн нь дахин үнэлэгдсэн хөрөнгийг данснаас хассантай холбоотой. Тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 7,381.5 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 9,237.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 589.3 сая төгрөгөөр өсгөн 9,826.6 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 03 дугаар тогтоол, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу тус байгууллагыг гүйцэтгэлээр санхүүжүүлж байгаа тул төсвийн гүйцэтгэлийн тайлан баталгаажуулаагүй болно.

Үндсэн дансанд эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр 8,107.8 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 125.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэн, төсвийн ерөнхийлөн захирагчаас 200.0 сая төгрөг, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд 125.0 сая төгрөгийн нийт 8,558.3 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлж үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогод 177.1 сая төгрөг, Коронавируст халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын албан хаагчид, эрүүл мэндийн байгууллагын ажилчдад нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд

475.5 сая төгрөг, Улаанбаатар хотод дайчлагдаж ажилласан эмч нарын цалинд 10.0 сая төгрөг, дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Эрүүл мэндийн яамнаас төслийн 20.3 сая төгрөг, Эрүүл мэндийн газраас аппаратын 10.0 сая төгрөг, дархлаажуулалтын зардалд 0.2 сая төгрөгийн орлого орсон байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Нэгдсэн эмнэлгийн 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 374 мэдээллээс Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 374 мэдээллээс 23 төрлийн 1,128.1 сая төгрөгийн өглөг, 4 төрлийн 1,597.4 сая төгрөгийн авлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4.2 сая төгрөгийн төлбөрийн акт, 18.2 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 47.7 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна. Үүнээс 2.1 сая төгрөгийн хувь хүмүүсээс авах авлагын шийдвэр хэрэгжээгүй хуулийн байгууллагад хандсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар өглөг, авлагын бүртгэл, гүйцэтгэлийн аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг үзэх нь зүйтэй. Цаашид ээлжийн ажилчдын цагийн бүртгэлийг баталгаажуулж, баримтын бүрдлийг хангах, тушаал шийдвэрт үндэслэн цалин бодож байхыг анхаарах хэрэгтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 922.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 917.6 сая төгрөгийн алдааг залруулж, 4.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 0.6 сая төгрөгийн зөрчилд

албан шаардлага хүргүүлэн, Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоотой 775.8 сая төгрөгийн залруулга хийгдсэн. Иргэн аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авалтын 141.8 сая төгрөгийн и баримтыг нөхөн шивүүллээ.

4.2 Төлбөрийн акт

Ажилчдын амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 0.9 сая төгрөгийн цалин илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Хэрэгжиж байгаа төслийн үлдэгдэл 3.1 сая төгрөгийг зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.7-т "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлан дахь татварын өглөг, авлага нь Татварын тодорхойлолтоос 0.6 сая төгрөгөөр зөрүүтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 374 мэдээллээс 23 төрлийн 1,128.1 сая төгрөгийн өглөг, 4 төрлийн 1,597.4 сая төгрөгийн авлагын мөнгөн гүйлгээг өрийг бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт мэдээлээгүй байна.

- 1.2. **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.8-т “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг	5	922.2	1	917.6	2	4.0	1	0.6	1	